



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/199

Цагаан-Уул сум

┌ Албан тушаалын тодорхойлолт ┐  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах 03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын орлогчийн албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр хавсралтаар, багийн Засаг даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүргийг цаг тухай бүрт нь чанартай зохион байгуулж, гүйцэтгэж ажиллахыг Засаг даргын орлогч, багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дагын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэцэцэг)-д даалгасугай.

ДАРГА  С. ГОНЧИГНЯМ





ХӨРӨГТӨЙ АЙМГИЙН  
ИТГЭЛИЙН ЗУМЫН  
ЗАСАГ ДАРГА

Урьдчилсан гэрээний үндсэн дээр 2020  
Урван тусгай зориулалтын газрын  
Тусгай зориулалтын газрын тусгай зориулалтын

№ \_\_\_\_\_  
-ийн № \_\_\_\_\_

A/200

Муух сумд  
шалгах тухалд



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/201

Цагаан-Уул сум

**Эрх бүхий албан тушаалтан  
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.3, Авлигын эсрэг хуулийн 11 дугаар зүйлийн 11.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дугаар зүйлийн 24.1.5, Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 05 тоот тогтоолын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Шагдарын Эрдэнэцэцэгийг 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс Эрх бүхий албан тушаалтнаар /ЭБАТ/ томилсугай.

2. Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ын нэмэгдлийг үндсэн цалингийн 40 хувиар тооцон олгохыг зөвшөөрсүгэй.

3. Албан тушаалтны хувийн ашиг сонирхолын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт түүнийг бүртгэх, хадгалах, хянах, тайлагнах, холбогдох нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс хууль тогтоомжийн хүрээнд хувь хүний нууцтай холбогдох мэдээллийг чандлан хадгалах, хамгаалахыг (Ш.Эрдэнэцэцэг) /ЭБАТ/-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хууль эрх зүйн мэргэжилтэн (Б.Ичинхорлоо)-д даалгасугай.

5. Уг захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/77 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.ГОНЧИГНЯМ

/Zahiramj 2024/